

АЖМХ НЭЗХЭ-ийн

АЖЛЫН АЛБАНД.

2025 оны 2 дугаар сарын 28.

Дугаар 08.

Улаанбаатар хот.

Хяналт хийх удирдамж хүргүүлэх тухай

АЖМХ-ны НЭЗХЭ-ийн дэргэдэх Хяналтын зөвлөлийн 2025 оны 02 сарын 26-ны өдрийн хурлын шийдвэрээр АЖМХ НЭЗХЭ-ийн дүрмийн 40.1; 40.2; 41.1.1 заалтуудыг үндэслэл болгон АЖМХ НЭЗХЭ-ийн ажлын албаны дарга М.Нарангэрэл танаа дараах хяналт хийх удирдамж хүргүүлж байна.

НЭГ. УДИРДАХ ЗӨВЛӨЛ, АЖЛЫН АЛБАНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА

- Удирдах зөвлөл, салбар холбоодын болон ажлын албаны 2024 оны жилийн эцсийн үйл ажиллагааны тайлан
- Салбар холбоо тус бүрийн гишүүнчлэлийн мэдээлэл (гишүүнчлэлийн төлбөрийн баримтыг хавсаргасан байх)
- Удирдах зөвлөлийн гишүүдийн хурлын ирцүүдийн мэдээлэл, хурлын тэмдэглэл
- Ажлын албаны ажилтнуудын хөдөлмөрийн гэрээ, ажлын байрны тодорхойлолт, үйл ажиллагаатай холбоотой гэрээ, тушаал, шийдвэрүүд, гомдол, санал хүсэлт шийдвэрлэлт
- Удирдах зөвлөл, Ажлын албаны 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, төсвийн төлөвлөлт
- Эвент арга хэмжээнүүдийн 2025 оны календарчилсан төлөвлөгөө, эвенттэй холбоотой санхүүгийн батлагдсан төсвийн танилцуулга.
- 2024 оны жилийн эцсийн үйл ажиллагааны тайланд хяналт хийхтэй холбогдуулан ажлын албаны хурлын танхимын хуваарийг 03 дугаар сарын 12-ны өдрөөс 03 дугаар сарын 16-ны хугацаанд бусад хуваариас чөлөөлж, Хяналтын зөвлөлийн гишүүдийн ажиллах боломж бүрдүүлсэн байх,

Хяналтын хугацаанд хөндлөнгийн ямар нэгэн нөлөөлөл үзүүлэхгүй байх, шаардалагтай тохиолдолд тухайн хариуцагчаас тайлбар авах боломжоор хангах

ХОЁР. САНХҮҮ ТАЙЛАН

Хяналтын зөвлөлийн санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийхэд дараах материалуудыг үдэж цэгцэлж, хэвлэн дэс дараагаар нь бэлтгэсэн байх шаардлагтай. Үүнд:

- 2024 оны батлагдсан ажлын төсөв, төлөвлөгөө
- Банкны баталгаажсан харилцахын хуулганууд
- Баталгаажсан тайлангууд /ААНОАТ, татварын бусад тайлан/
- Санхүү байдлын тайлан
- Касс харилцахын тайлангууд сар бүрээр үдэгдсэн байх /Ибаримтыг нь хавсаргасан байх/
- НДШ-н тайланг сар бүрээр баталгаажуулж хавтасласан байх /Ажилчдын орж гарсан тушаалыг хавсаргах/
- Гүйлгээ баланс
- Үйл ажиллагааны зардалыг нотолсон тайлангууд
- Өглөг, авлагын дэлгэрэнгүй тайлан
- Үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй тайлан
- Бараа материалын дэлгэрэнгүй тайлан

АЖМХ НЭЗХЭ-ийн дэргэдэх ХЯНАЛТЫН ЗӨВЛӨЛ